



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/81

Арвайхээр

Батлан хамгаалахын хууль тогтоомж,
шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт,
зөвлөн туслах ажил явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 18 дугаар зүйлийн 18.1.1 заалт, Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм”-ийн 3.1, 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт, зөвлөн туслах ажил явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Дайчилгааны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль тогтоомжийн биелэлт, хэрэгжилтэд хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг чанартай зохион байгуулж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулах Цэргийн штаб (хурандаа М.Дэлгэрсайхан)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

011100178

Аймгийн Засаг даргын 2021 оны...
дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗӨВЛӨН ТУСЛАХ АЖИЛ ЯВУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: М.Дэлгэрсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын дарга, хурандаа)

Нарийн бичгийн дарга: Ч.Адъяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт,
сургалтын офицер, дэд хурандаа)

Гишүүдэд: Б.Өлзийбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын Тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа)

З.Нацагням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХЭЗХ-ийн
хууль эрх зүйн сургалт сурталчилгааны асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Р.Цэрэндэжид (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн төсвийн ахлах мэргэжилтэн,
Улсын дайчилгааны мэргэжилтэн, бэлтгэл дэслэгч)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны ...
 дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
 захирамжийн хоёрдугаар хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН
 НЭГЖҮҮДЭД 2021 ОНД БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
 ШАЛГАН ТУСЛАХ АЖЛЫН ХУВААРЬ

| № | Байгууллагуудын нэр | 2021 он | | | | | | | | | | | | Тайлбар |
|---|---|------------------|---|---|-------------------|---|---|--------------------|---|---|--------------------|----|----|---------|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | |
| | | Нэгдүгээр улирал | | | Хоёрдугаар улирал | | | Гуравдугаар улирал | | | Дөрөвдүгээр улирал | | | |
| 1 | Политехникийн коллеж | + | | | | | | | | | | | | |
| 2 | Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль | | | | + | | | | | | | | | |
| 3 | Биеийн тамир, спортын газар | | | | | | | + | | | | | | |
| 4 | Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль | | | | | | | | | | + | | | |
| 5 | Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль | | | | | | | | | | + | | | |